



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2024 ОН Ы “ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ ЧИГЛЭЛ”-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024.01.18

Дархан-Уул аймаг

**ЗОРИЛГО:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

**ҮР ДҮН:** 1. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, соёлын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн харьяа байгууллагуудыг мэдээллээр хангасан байна.

2. Соёлын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогын хэрэгжилтийн талаарх мэдлэг, арга замын талаарх ойлголтыг бүх түвшинд түгээсэн байна.

3. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд болон иргэнийг ажилд авахад нас, хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, газрын байршил болон бусад зүйлээр үл ялгаварлах, ажлын байранд бэлгийн дарамт шахалт үүсэхгүй байх зохицуулалт, нөхцөл бүрдэнэ.

**ЗОРИЛТ:** 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, соёлын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сайжруулах.

2. Салбарын ажилтнуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар дэмжих, мэдлэг, судалгаа, мэдээлэлд суурилсан хэрэгжүүлэх.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах эзэн
<b>1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, жендэрийн үндэсний хорооноос гарсан шийдвэр, соёл, урлагийн газарт жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах.</b>				
1.1	Байгууллагын төлөвлөгөө гаргаж газрын даргаар батлуулах	-Төлөвлөгөөг батлуулсан байна.	I улирал	Хэлтсийн дарга С.Туяа Мэргэжилтэн Б.Долгормаа
	Жендэрийн тэгш байдлыг хангах, тус газарт жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх талаар	-Хэрэгжилтийг сайжруулах авч хэрэгжүүлсэн арга		Хэлтсийн дарга С.Туяа

1.2	сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ чиглэлд төр, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.	хэмжээний тоо, үр дүн, сургалт, сурталчилгааны ажлын тоог гарсан байна.	I-IV улирал	Мэргэжилтэн Б.Долгормаа
1.3	Салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр, бодлого боловсруулалт, хэрэгжилтэд болон байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн бүлгийн оролцоотой хэлэлцэн, шийдвэрлэсэн байх	-Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог хангах, тэдний хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. -Байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тэдний санал, бодлыг сонссон байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга С.Туяа Мэргэжилтэн Б.Долгормаа
1.4	Жендэрийн Үндэсний хороо болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт соёлын салбарын албан хаагчдыг идэвхтэй хамруулах	-Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа гаргасан байна. -Тайланд хавсаргасан байна.	I-IV улирал	Мэргэжилтэн Б.Долгормаа
1.5	Соёлын салбарын жендэрийн тэнцвэрт байдлын судалгааг гаргах	-Тоо, үр дүнг гаргаж, тайланд хавсаргасан байсан.	III улирал	Архив-бичиг хэрэг, нярав Д.Ариунжаргал
1.6	Зорилтот бүлгийн хүмүүсийг хүйс харгалзахгүй эрүүл мэндийн үзлэгт хамруулах	-Эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эмчлэгдэх боломжтой хүнийг эмчилгээнд хамруулах	I-IV улирал	ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн П.Цогцэцэг
1.7	Иргэд олон нийтэд жендэрийн мэдлэгийг олгох зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зурагт хуудас бэлтгэн хүргэх	-Олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга Б.Чинбилэг Мэргэжилтэн Б.Долгормаа
<b>2. Салбарын ажилтнуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар мэдлэг, судалгаа, мэдээлэлд суурилан хэрэгжүүлэх.</b>				

2.1	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, холбогдох арга хэмжээг авч байх, ажлын ачаалал, хөдөлмөрийн цаг, нормыг баримтлан хэрэгжүүлэх	-Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан албан хаагчдын тоо, үр дүнг гаргасан байна.	I-IV улирал	Мэргэжилтэн Б.Долгормаа Архив-бичиг хэрэг, нярав Д.Ариунжаргал
2.2	Хүний нөөцийн асуудлаар ялгаваралгүйгээр шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, шударга, хувь хүнтэй зөвшилцлийн замаар шийдвэрлэх нөлөөллийг бий болгох арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх	-Шийдвэр хууль тогтоомжийн дагуу гарсан байна. -Хүний нөөцийн талаарх шийдвэртэй холбогдон гарсан гомдол, саналын тоог гаргасан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга С.Туяа Архив-бичиг хэрэг, нярав Д.Ариунжаргал
2.3	Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил арга хэмжээг зохион байгуулах	-2-оос доошгүй ажил зохион байгуулсан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга С.Туяа Мэргэжилтэн Б.Долгормаа
2.4	Жендэрийн асуудлаар мэргэшсэн сургагч багштай болох	-1 багш бэлтгэсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга С.Туяа
2.5	Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэх	-Тайланг үнэн бодитой гаргасан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга Б.Чинбилэг Мэргэжилтэн Б.Долгормаа

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН *Б.Долгормаа* Б.ДОЛГОРМАА